

## БНСУ-ЫН ИРГЭНИЙ ГАДААД ИРГЭНШИЛТЭЙ НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮҮХЭД, ЭСВЭЛ БНСУ-ЫН ИРГЭНТЭЙ ГЭРЛЭЖ ДУНДААС НЬ ТӨРСӨН ХҮҮХЭД (F- 2- 2)

**1. Олгох хүрээ: F-2-2:** БНСУ-ын иргэний гадаад иргэншилтэй насанд хүрээгүй хүүхэд, эсвэл БНСУ-ын иргэнтэй гэрлэж дундаасаа төрсөн хүүхэд

**2. Визний төрөл:** 1 жил хүртэлх хугацаатай нэг удаагийн виз

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД
1. Виз мэдүүлгийн маягт, сүүлийн 6 сарын дотор авахуулсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь
3. Цагдаагийн газрын тодорхойлолт (18–аас дээш, 60-аас доош насны анх удаа зорчиж буй иргэнд хамаарна)
4. Сүрьеэгийн шинжилгээний бичиг ( <b>ЭСЯ-аас заасан сүрьеэгийн шинжилгээ өгөх эмнэлэг хавсралт 2</b> )
УРИГЧ ТАЛЫН БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД
1. Урилга (ЭСЯ-ны маягтын дагуу) Уригч нь урилга дээр өөрийн хувийн тамгаа дарж (гарын үсэг зурж), тамгын гэрчилгээ (гарын үсгийн гэрчилгээ)-ний эх хувийг хавсаргах эсвэл нотариатаар баталгаажуулсан байна
2. Батлан даалтын бичиг (ЭСЯ-ны маягтын дагуу, Батлан даах хугацаа: БНСУ-ын хилээр нэвтэрсэн өдрөөс эхлээд 2 жил)
3. Гэр бүлийн холбоо хамаарлыг нотлох бичиг (Төрсний бүртгэлийн лавлагаа эсвэл ДНХ шинжилгээний тодорхойлолт зэргээр төрсөн эцэг/эх, үр хүүхэд нь мөн эсэхийг баталгаажуулах албан ёсны бичиг баримт
4. Оршин суух хаягаа нотлох бичиг баримт <ul style="list-style-type: none"> <li>• Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар, Түрээсийн гэрээ (Хамаарах тохиолдолд)</li> </ul>
5. Уригчийн санхүүгийн чадвар нотлох бичиг баримт <ul style="list-style-type: none"> <li>• Орлого нотлох тодорхойлолт (БНСУ-ын Татварын Ерөнхий Газар), Ажлын газрын тодорхойлолт, Дансны хуулга зэрэг зээл төлбөр мэдээллийн лавлагаа (БНСУ-ын Банкны Холбооноос авах)</li> </ul> <p><b>Ø Өөрийн болон хамт амьдарч буй шууд холбоо хамааралтай гэр бүлийн гишүүд болон эхнэр/нөхөр (Уригдагч)-ийн виз мэдүүлэх өдрийг хүртэлх сүүлийн 1 жилийн орлогын нийт хэмжээ нь өнгөрсөн онд БНСУ-ын Төв банкнаас зарласан нэг хүнд ногдох үндэсний нийт орлого (GNI)-ын хэмжээнээс дээш байх</b></p> <p><b>Ø 2023 оны байдлаар нэг хүнд ногдох (GNI) нь 44,050,000 вон</b></p> <p><b>Ø Хамт амьдарч буй гэр бүлийн гишүүдийн тоо 3 ба түүнээс доош байх тохиолдолд GNI-ийн 70%-аас дээш байх (30,835,000 вон)</b></p>
6. БНСУ-ын иргэн өөрийн гадаад иргэншилтэй хүүхдээ урьж байгаа тохиолдолд асран хамгаалах эрхтэй эсэхээ нотлох бичиг баримтыг бүрдүүлэх ба бүрдүүлэх боломжгүй тохиолдолд тухайн насанд хүрээгүй хүүхэдтэй ижил иргэншилтэй асран хамгаалагч харгалзан дэмжигчийн зөвшөөрлийн бичгийг бүрдүүлж өгнө.
Ø <b>Анхаарах зүйлс</b> <ul style="list-style-type: none"> <li>• Асран хамгаалагч харгалзан дэмжигч байхгүй тохиолдолд, байхгүй нь үнэн гэдгийг нотлох албан ёсны бичиг баримт эсвэл нотариатаар баталгаажуулсан бичиг баримт</li> </ul>